



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/119

Чингис хот


Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 35.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Тулга констракшн" ХХК-аас аймгийн орон сууцны санд төлөх 247 581 171 /хоёр зуун дөчин долоон сая таван зуун наян нэгэн мянга нэг зуун далан нэгэн/ төгрөгийг нэхэмжлэх тухай иргэний хэрэгт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, 25.1.2, 25.1.3, 25.1.4, 25.1.5, 25.1.6, 25.1.7, 25.1.8 дахь заалтуудад заасан бүрэн эрхийг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Б.Дарханбаатар/-д олгож аймгийн Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр /хэрэг хянан шийдвэрлэх хугацаагаар/ томилсугай.

2. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд нэхэмжлэгчийг бүрэн төлөөлж итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Б.Дарханбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010228